



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/104

Улаанбаатар хот

Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын
данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/61 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн харилцааны газраас 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлага худалдаагаар худалдсан 6,200,000 (зургаан сая хоёр зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Хьюндай Элентра маркийн 76-09 УНН, 42,181,000 (дөчин хоёр сая нэг зуун наян нэгэн мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Хьюндай Элентра маркийн 51-31 УБӨ, 5,000,000 (таван сая) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Хьюндай Элентра маркийн 89-67 УНЭ, 5,400,000 (таван сая дөрвөн зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Киа Рио маркийн 20-10 УНУ, 5,400,000 (таван сая дөрвөн зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Киа Рио маркийн 20-29 УНУ, 5,400,000 (таван сая дөрвөн зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Киа Рио маркийн 20-48 УНУ, 5,400,000 (таван сая дөрвөн зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Киа Рио маркийн 20-51 УНУ, 5,400,000 (таван сая дөрвөн зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Киа Рио маркийн 20-79 УНУ улсын дугаартай тээврийн хэрэгслүүдийг данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (Р.Отгонжаргал)-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (Р.Отгонжаргал)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (П.Магнайбаатар)-т тус тус даалгасугай.

ДАРГА



М. БАЯРАА

115050000297